



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

### Дугаар №30



2018 оны 8-р сарын 27-31

#### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1193** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 105(8.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1062(89%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 7(0.6%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

##### 1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1062** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.9%-иар бага байна. Эпидемиологийн 34-р долоо хоногтой харьцуулахад 44.4%-иар буурсан үзүүлэлттэй байна.



Хачигт риккетсиозын 788 сэжигтэй тохиолдлын 185(23.4%), хачигт энцефалитын 183 сэжигтэй тохиолдлын 32(17.5%), хачигт боррелиозын 91 сэжигтэй тохиолдлын 24(26.4%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 129 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.


##### 1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **105** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11%-иар бага байна. Эпидемиологийн 34-р долоо хоногтой харьцуулахад 1 эрсдэлд өртсөн тохиолдлоор илүү байна.



### 1.3 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 53 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 2%-иар бага байна. Эпидемиологийн 34-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



8 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийслэлийн БГД, ХУД, СХД-ийн хэмжээнд 4 удаагийн ирүүлсэн амьтны дуудлагад үйлчилсэн. Сорьц материалд лабораторийн шинжилгээ хийгдэж байна.

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Монгол улсад:

#### Мал, амьтны галзуу өвчин:

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Алтгана багийн “Цагаантолгой” гэдэг газар 8-р сарын 24-ны өдөр малчин “Э”-ийн 1 үхэрт мал, амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээний дүнгээр галзуу өвчин болох нь тогтоосон байна. Тус суманд хязгаарлалтын дэглэм тогтоосон. Нийт 8 өрх айлын 21 хүнд үзлэг хийж, 12 өрхийн 48 хүнд галзуу өвчнөөс сэргийлэх сургалт сурталчилгаа хийгджээ.



Эх сурвалж: ОБЕГ, Хөвсгөл аймгийн ЗӨСТ

## Олон улсад:

### Эбола вирус халдвар:

БНАК улсад 8 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 103 сэжигтэй (76 батлагдсан, 27 болзошгүй) тохиолдол, үүнээс 63 нас баралт мэдээлэгдээд байна. Тус улсын Хойд Киву, Итури мужуудад Эбола вирусийн дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна.



Эх сурвалж: ДЭМБ

### Шар чичрэг өвчин:

8 дугаар сарын 14-нд Франц улсад шар чичрэг өвчний тохиолдол батлагдсан тухай ДЭМБ, Франц улсын Үндэсний лавлагаа лабораторийн төвөөс мэдээлсэн байна. Өвчтөн 47 настай, эрэгтэй. 2018 оны 4 дүгээр сараас эхлэн Франц улсын Гвиней хотын Рура мужийн ойд зам тавих ажил хийж байсан. 8 дугаар сарын 4-өөс ханиах шинж тэмдэг илэрч, 8 дугаар сарын 8-нд Гвиней мужийн Сауенне эмнэлэгт түргэн даамжирах элэгний үрэвсэл (fulminant hepatitis) оноштойгоор хэвтсэн байна. Улмаар 8 дугаар сарын 09-нд Парис хот руу элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр шилжүүлсэн. Шар чичрэг өвчний вакцинд хамрагдаагүй. 8 дугаар сарын 10-нд Францын үндэсний лавлагаа лабораторийн шинжигээгээр шар чичрэг болох нь батлагдсан байна.

Эх сурвалж: ДЭМБ

### Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын Орёл мужид Африкийн гахайн мялзан өвчин гахайн аж ахуйд бүртгэгдэж, 984 гахай өртсөнөөс, 19 нь өвчилж үхэн, 107 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДЭМБ

### Адууны ям өвчин:

БНХАУ-ын Jiulongpo мужид *Burcholderia mallei* үүсгэгчээр үүсгэгдсэн Адууны ям өвчин бүртгэгдсэн тухай ДЭМБ-аас мэдээлжээ. Нийт 17 адуу өртсөнөөс, 1 адуу өвчилж үхсэн ба 16 адууг устгасан байна. Ям өвчин нь адуунд голдуу архаг, далд хэлбэрээр илэрдэг байна.



Эх сурвалж: ДЭМБ

### Хонины цэцэг өвчин:

ОХУ-ын Москва мужид Каприпокс вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин аж ахуйд бүртгэгдэж, 104 хонь өртсөнөөс, 11 нь өвчилж, 2 хонь өвчилж үхсэн, 1 хонийг устгасан. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.



**Жич:** Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Өмнөговь, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Ховд, Хөвсгөл аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн [eop@nczd.gov.mn](mailto:eop@nczd.gov.mn) мэдээгээ ирүүлж байна уу?